https://doi.org/10.69561/mjac.v25i49.3843 **Article | Fasc.18**

Монгол шуудангийн маркийн дүрслэл, агуулгын хөгжлийн судалгаа

Сундуйн Өлзиймаа
Шинжлэх ухаан технологийн их сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Дизайны тэнхим, Улаанбаатар, Монгол Улс
ulziimaa.s@must.edu.mn

Хураангуй: Шуудангийн марк нь шуудангийн үйлчилгээнд ашиглагддаг, тодорхой үнэ цэнээр баталгаажсан төлбөрийн хэрэгсэл болохоос гадна тухайн улсын соёл, урлаг, түүхийг харуулсан өвөрмөц бэлгэ тэмдэг болдог. Марк нь тухайн улсын үндэсний урлагийн хэв маяг, түүхэн үйл явдал, байгалийн үзэсгэлэнт газрууд болон соёлын өвийг дүрслэн гаргаж, олон нийтэд түгээдэг урлаг, дизайн, мэдээллийн чухал элемент юм. Түүнчлэн, улс хоорондын харилцаа холбоо, олон улсын стандартын дагуу харилцан мэдээлэл солилцох хэрэгсэл болж өгдөг. Соёл, урлагийн ач холбогдлоос гадна тухайн улс орны төрийн бодлого, нийгмийн чиг хандлага, эдийн засгийн хөгжлийг илэрхийлэх чухал үүрэгтэй юм. Маркийн дүрслэл илэрхийлэмж нь график дизайны үйл ажиллагаа бөгөөд уг судалгааны ажлаараа маркийг хэрэглэгдэхүүн болгон авч үзэн, монгол маркийн уламжлалт хэв маяг, сэдэвчилсэн агуулга, түүний хэлбэр дүрслэлийн онцлогийг ажиглалт, харьцуулалт, семиотикийн аргаар илрүүлэхийг зорилоо. Монгол марк нь агуулга болон дүрслэлийн өвөрмөц шинжүүдийг агуулж байдаг тул онцгой ач холбогдолтой гэж үзэн энэхүү өгүүллээ бичлээ.

Түлхүүр үгс: *формат, зохиомж, элемент, график дизайн, хэрэглээний урлаг*

A study on the development of the image and content of mongolian postage stamps

Ulziimaa Sundui
Department of Design, School of industrial Technology, Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia
ulziimaa.s@must.edu.mn

Abstract: Postage stamps are used in postal services, serve as a means of payment, and are unique symbols that reflect the culture, art, and history of a country. They are important elements of art, design, and communication, depicting a nation's artistic style, historical events, natural beauty, and cultural heritage while being distributed to the public. Additionally, stamps act as a medium for communication between countries and the exchange of information in accordance with international standards. Beyond

Received: 2024.07.24/ Accepted: 2024.12.05 *© Author (s). 2024*

their cultural and artistic significance, postage stamps play a crucial role in expressing state policies, social trends, and economic development. The visual expression of stamps is a form of graphic design. In this research, we aim to explore the traditional styles, thematic content, and design characteristics of Mongolian stamps through observation, comparison, and semiotic analysis. This article was written to highlight the unique content and visual features of Mongolian postage stamps.

Keywords: *format, composition, elements, graphic design, applied art*

Оршил

Шуудангийн марк нь захидал, илгээмжийн төлбөрийг урьдчилан төлөх үндсэн үүрэгтэй төлбөрийн хэрэгсэл хэдий ч, нөгөө талаараа түүн дээрх онцгой дүрслэл, агуулга, түүнийг илэрхийлэх дизайны онцлогоороо нэгэн төрлийн хэрэглээний урлаг болох шинж тэмдгийг давхар илтгэдэг. Хэрэглэгчид түүнийг төлбөрийн хэрэгсэл төдийхнөөр биш хэрэглээний урлаг,[1] дизайны бүтээл, бүтээлч үйлдвэрлэл гэдэг үүднээс сонирхон цуглуулдаг байна.

Марк нь ном, зурагт хуудас зэрэг хэвлэмэл бүтээлийн нэг болох бөгөөд тухайн хувь уран бүтээлч, байгууллагын харах өнцөг, чиг хандлагаар үйл явдлын өнгө төрхийг чөлөөтэй илтгэн бүтээгддэг. Шуудангийн маркийн ялгарах онцлог нь шуудангийн хувьд мөнгөн дэвсгэрт, үнэт цаас болдог, мөн тухайн маркийн сэдэв, агуулгыг Засгийн газраас баталж, улс орноо төлөөлсөн улс төрийн хэм хэмжээг тогтоосон агуулга дүр дүрслэлийг илтгэдэгт оршино.

1840 онд Их Британийн хатан хааны хөрөг дүрс бүхий “Penny Black” шуудангийн анхны маркийг бүтээснээр урлаг, соёлын энэхүү шинэ салбар үүссэн гэж үздэг (Cheshire 2017) ба өдийг хүртэл харилцаа холбооны төдийгүй урлаг дизайны үнэт бүтээл болон өргөжсөөр байна. “Penny Black” буюу “Хар пенни” нь нийтийн шуудангийн системд ашиглагдсан анхны наалдамхай шуудангийн марк бөгөөд Rowland Hill-ийн санаачилгаар (Hill 1880, 386) тус марк дээр Их Британийн хатан хаан Викториагийн хөрөг дүрсийг дүрсэлсэн байдаг (*Зураг 1*). Хатан хааны хөргийг дүрсэлснээрээ тус маркт Их Британи буюу улсын нэрийг бичих шаардлагагүй, түүнийг шууд таних бэлгэ тэмдэг гэж үзсэн бөгөөд “Postage stamp”, “One penny”, “FA” зэрэг хэвлэмэл хуудсан дээрх үсгэн тэмдэглэгээнүүдийг зөвхөн хар өнгөөр дүрсэлсэн байдаг. Дэлхийн хамгийн үнэтэй маркнуудын нэгд албан ёсоор тооцогддог тус марк нь орон нутагт буюу зөвхөн Их Британи, Ирландын нэгдсэн вант улсын нутаг дэвсгэрт ашиглагддаг байж (Hill 1880).

Зураг 1. *“Penny Black” нийтийн шуудангийн системд ашигласан анхны марк*

[1] Хэрэглээний урлаг гэдэг нь уран сайхны дизайныг практик болон үйл ажиллагааны объектод хэрэглэхийг хэлнэ.

Судалгааны арга зүй

Монгол маркийн дүрслэл илэрхийлэмж нь график дизайны үйл ажиллагаа бөгөөд уг судалгааны ажлаараа монгол маркийн хэв маяг, сэдэвчилсэн агуулга түүний хэлбэр дүрслэлийн хөгжлийн онцлогийг ажиглалт, харьцуулалт, семиотикийн аргыг ашиглан дүн шинжилгээ хийсэн. Мөн Монгол шуудангийн марк бүтэх үйл явцыг диаграммчлан тодорхойллоо.

Судалгааны үр дүн

Шуудангийн марк нь соёлын объект, түүхийн эх сурвалж бөгөөд нийгмийн амьдралд болж буй үйл явдал, өнгөрсөнд болон одоо байгаа объект, газар нутгийн төрөл, үйл явц, байгалийн үзэгдлийн талаарх дүр дүрслэл болон бичмэл мэдээллийг тээвэрлэгч, түгээн дэлгэрүүлэгч юм. Шуудангийн марк нь урлагийн өндөр чанартай төрийн баримт бичиг бөгөөд тухайн улсын бүхий л үйл ажиллагаа, соёлын ололт амжилтыг сурталчлах арга хэрэгсэл юм (К.Н.Сабур 2019). Тиймээс бид маркийг урлагийн бүтээл, түүн дотроо график дизайны объект талаас нь судалж, онцлог шинж чанарыг тодорхойлох юм.



Зураг 2. *Шуудангийн марк бүтэх үйл явц (Судлаачийн эх сурвалж)*

Үүний тулд шуудангийн марк бүтэх үйл явцыг авч үзье (*Зураг 2*). Монгол марк нь Монгол Улсын шуудангийн тухай хууль, түүнд хамрагдах бичиг баримт, дүрэм журамд захирагдана. Шуудангийн тухай хуулийн хоёрдугаар бүлэг "Шуудангийн талаарх төрийн зохицуулалт" 7.1.5-д "Үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн үйлдвэрлэлт, борлуулалт, дахин үнэлэлт, улсын фондын баяжуулалт, хадгалалт, хамгаалалтын журмыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих" (Шуудангийн тухай хууль 2021, УИХ), долоодугаар бүлэг 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 25.3-т "Шуудангийн илгээмж дээр "Монгол" гэсэн тодотгосон үгтэй шуудангийн марк наасан байна. Шуудангийн марк нь Монгол Улсын тусгаар тогтнолыг илэрхийлсэн, шуудангийн илгээмжийн төлбөр төлөгдсөнийг баталгаажуулсан, үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн төрөл бөгөөд үнэ бүхий шуудангийн тэмдэгт маркийг

үйлдвэрлэх, борлуулах, хадгалах бодлогыг Засгийн газар батална” (Шуудангийн тухай хууль 2021, УИХ) гэж хуульчилсан байна. Мөн Засгийн газрын тогтоолоор ирэх жил хэвлэгдэх шуудангийн маркийн сэдвийн төлөвлөгөөг батлуулан ажилладаг нь шуудангийн марк нь Засгийн газраас бүрэн хамааралтайг илтгэнэ.

Маркийн газар[2] ирэх жилд ямар сэдвийг онцлохыг судлан, ерөнхийлсөн сэдвээ Засгийн газраар батлуулдаг. Энэ нь тус марк дээрх дүр дүрслэлийг нэг бүрчлэн баталж байгаа биш бөгөөд маркийн газар тухайн сэдэвт харгалзах судалгааг нийгэм соёлын олон талт байдлаар судлан, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон концепц санаагаа боловсруулна. Боловсруулсан санаа агуулга дээр тулгуурлан маркийн зураач, дизайнерууд маркийн дүр дүрслэл, дизайны онцлог, чиг хандлагыг тодорхойлж, дизайны шийдлийг хэд хэдэн хувилбараар бүтээж эцсийн хувилбарыг тогтон хэвлэнэ. Тодорхой хувь тоогоор хэвлэгдэн бэлэн болсон марк нь зах зээлд Засгийн газраас тогтоосон нэрлэсэн үнээр нийтийн хүртээл болдог. Ингэж бүтээл болон дэлгэрэхэд шуудангийн маркийн урлал онцгой чухал үүрэгтэй юм.

Маркийн дизайн нь зорилгоо хангалттай биелүүлэхэд шаардлагатай хэд хэдэн элементүүдийг зайлшгүй агуулдаг. Үүнд:

Олон улсын шаардлагын дагуу тухайн улсын нэр, нэрлэсэн үнэ буюу маркийн үнийг араб тоогоор, мөнгөний нэгжийг үсгээр, мөн тухайн улсын уламжлал, үнэт зүйлийг бэлгэддэг хүмүүс, үйл явдал, байгууллага, байгалийн бодит байдлыг агуулсан дүр дүрслэл, нэмэлтээр маркийн сэдэвт хамрах бичвэр, зураач, дизайнерын нэрийг багтаадаг. Дэлхийн шуудангийн холбооноос маркийг олон улсад ашиглах тохиолдолд улсын нэрийг заавал латин үсгээр бичсэн байх ёстой гэж дүрэмчилсэн байна (Union 2012). Гэсэн хэдий ч английн “Penny Black” хэмээх анхны марк дээр энэ үүргийг хатан хаан Викториагийн хөрөг гүйцэтгэсэн байдаг. Энэ нөхцөл байдал нь бичээсний тоог багасгах боломжийг олгож, бага зайд бичвэр болон нэмэлт элементүүдийг багтааж, хэт ачаалалгүйгээр график дизайны шийдлийг боловсруулах таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Шуудангийн маркийг хэрэглээний урлаг талаас нь авч үзвэл, түүний хөгжил, эдийн засгийн нөлөө, нийгэм цаг үеийн шаардлагаар загвар дизайнд өөрчлөлтийг хийж, хэрэглэгчид болон цуглуулагчдын гоо зүйн хэрэгцээг хангах шаардлага тулгарсан. Хэрэглээний урлагийн гол чиглэл болох тухайн объектын гоо зүйн сэтгэл татам байдал, үйл ажиллагааг уран бүтээлчид оногдсон сэдвийн хүрээнд бүтээлч ур чадвараа ашиглан тодорхой зорилго, чиг үүрэг бүхий объектыг загварчлан бүтээх бөгөөд тус тодорхойлолтод шуудангийн маркийн загвар дизайн нийцэх явдал юм.

Шуудангийн маркийн хэд хэдэн шинж чанарууд нь түүнийг зурагт хуудасны бүтэцтэй ойртуулах тал бий. Үүний жишээ нь агуулгын товчлол, сэтгэл татам дүрслэл, илэрхийлэмж юм. Гэхдээ хэрэглээний урлагийн хувьд зөвхөн шуудангийн марк нь олон функциональ төрөл буюу мэдээллийн, уран сайхны, дурсгалын шинж чанаруудыг нэгтгэж төвлөрүүлдэг уран бүтээл юм.

Маркийн дизайн нь дараах график элемент, шинж чанарыг агуулдаг.

1. Хэлбэр, хэмжээ

[2] Шуудангийн байгууллагыг шуудангийн марк, үнэт цаасаар хангах хангамжийн үүргийг гүйцэтгэх, маркийг зах зээлд сурталчилж гадны зах зээлд борлуулах газар

2. Бэлгэдлийн дүрслэл
3. Уламжлалт хэв маяг, график зохиомж, ерөнхий товч байдал
4. Цуврал маркийн хувьд нэгдсэн зохиомж, найруулга
5. Мэдээллийн нэгдэл
6. Чимэглэл зургийн нийлэмжтэй зохиомж авалт
7. Сэдэвчилсэн агуулга түүний өнгөний зохиомж
8. Хэвлэлийн технологи, онцгой арга техник

Монгол маркийн хувьд дээрх шинж чанарыг агуулсан, үндэсний онцлогоо илэрхийлсэн шуудангийн анхны марк нь "Элдэв Очир" нэртэйгээр 1924 оны 7-р сарын 8-ны өдөр нийтийн хэрэгцээнд гарч, шуудангаар явах захидал бичигт наагдан, өөрийн орны дотор болон гадаад улс орнуудад түгэн тархсан байна (Төмөрхүү 2011, 297). Анхны 7 нэгж марк "Элдэв Очир" (*Зураг 3*), хоёрдох 9 нэгж "Соёмбо" (*Зураг 4*) марк дээр тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан улсын нэр бичиж хэвлээгүй байдаг. Гэсэн хэдий ч тусгаар улс гэсэн бахархлаа дүрслэх урлагаар дамжуулан, солбисон очир буюу "Эрдэв Очир", төрийн сүлд "Соёмбо"-оор бэлгэдлээ болгон улсаа тунхаглан дүрсэлсэн байна.

1926 оны 11-р сарын 5-нд гаргасан хоёр нэгж "Соёмбо" марк дээр үндэсний бичгээр "Бүгд Найрамдах Монгол Улс", олон улсын шуудангийн холбооны дүрмийн дагуу латинаар "Mongolia" гэж бичсэнээр улсын нэрээ анх удаа тэмдэглэн хэвлэсэн түүхэн марк болсон (*Зураг 5*).

Зураг 3. *"Элдэв Очир" Монголын анхны марк*

Зураг 4. *"Соёмбо" марк анхны хэвлэл*

Зураг 5. *"Соёмбо" марк хоёрдох хэвлэл*

1932 оны 7-р сарын 10-нд "Шинэ Монгол" сэдэвт 13 нэгж марк хэвлэгдэж, тус маркаас эхлэн монгол маркийн дүрслэлийн чиг хандлагад огцом өөрчлөлт орсон байна.

MONGOLIA
10 POSTAGE 10
MONGOLIA
MONGOLIA
MONGOLIA

Маркийн хэлбэр, хэмжээ, зохиомж, дүрслэлийн хувьд, 1959 оны 6-р сард Унгар улсад хэвлэгдсэн "Үндэсний спорт" сэдэвт найман нэгж марк нь монголын маркийн урлагт шинэ содон төрхийг дүрслэл, дизайн, хийцээрээ шинэчлэн оруулж ирсэн байна (*Зураг 8*). Энэ нь ромбо хэлбэр юм. Мөн үндсэн болон үүсмэл олон өнгийн нэгдлийг ашиглан, бичвэрийн хувьд "БНМАУ", "Шуудан", "Mongolia", "10 мөнгө" зэргийг дизайны гол элемент болгон дүрсэлсэн байна. Үндсэн дүрслэл зургийг хүрээнээс гарган задгай зурж зохиомжилсон нь тус маркийг илүү сонирхолтой болгохоос гадна марканд үе дамжин уламжлан ирсэн чимэглэл болох хээ угалзын өнгө зураглалын нийлэмжийг үүсгэн дизайныг нь бүтээжээ. Үүний араас "Монголын ховор амьтад" (*Зураг 9*), "Мөөг" (*Зураг 10*), "Антарктид судлал" (*Зураг 11*) зэрэг өвөрмөц, чөлөөт хэлбэр хэмжээтэй маркнууд хэвлэгдэж байжээ.

Зураг 8. *"Үндэсний спорт" багц марк 1959 он*

Зураг 9. *"Монголын ховор амьтад" 1959 он 7 нэгж марк*

Зураг 10. *"Мөөг" 1978 он 7 нэгж марк*



Зураг 11. *"Антарктид судлал" 1980 блок марк*

Шуудангийн маркийг илэрхийлэх онцлог шинжүүдийн нэг бол цоолбортой[3] буюу шүдтэй марк юм (Society 2024) (*Зураг 12*). Дэлхийн анхны марк болох "Penny Black"-ийн дизайны хувьд цоолборгүй шийдсэн байдаг. Түүнийг ашиглахдаа ширхэг бүрээр хайчаар хайчлах, урах зэргээр салгаж хэрэглэдэг байж. Энэ нь хэрэглээний хувьд ашиглахад ихээхэн хүндрэл үүсгэхээс гадна маркийг гэмтээж байсан байна. Үүнийг 1854 онд маркийн зах хэсгээр цоолбор хийж анхны цоолбортой маркийг худалдаанд нэвтрүүлснээр хэрэглээний үүднээс хялбар болгожээ (*Зураг 13*). Энэ үйлдэл нь маркийг хэрэглээний урлаг талаас, хэрэглэгчийн зүгээс анх авч үзсэн шийдэл байсан.

Зураг 12. *Цоолбортой буюу шүдтэй марк*

Зураг 13. *"Penny Red" анхны шүдтэй марк 1854 он*

Монгол маркийн хувьд, анхнаасаа шүдтэй хэвлүүлж байсан нь дэлхийн маркийн дизайны хөгжил, туршлага манай марканд ч шингээстэй байсныг илтгэнэ. Гэсэн хэдий ч маркийн загвар өөрчлөгдөхийн хэрээр 1965 онд "Олон улсын цахилгаан холбоо" байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан блок маркийг шүдтэй, шүдгүй хоёр янзаар хэвлэсэн байна (*Зураг 14*), (*Зураг 15*).

Нэг сэдвийн хүрээнд нэг эсвэл хэд хэдэн маркийн нийлбэрийг нэг дор загварчлан дизайны шийдлийг боловсруулж агуулгаа илэрхийлсэн цогцолбор маркийг блок марк гэж нэрлэнэ. Блок маркийг ихэвчлэн үйл явдлын дурсгалд зориулан бүтээх нь олон байдаг. Тус шийдэл нь маркийн загвар дизайны хувьд зураач болон дизайнеруудад илүү олон боломжийг олгодгоороо давуу талтай. Энэ нь нэг жижиг марканд нэг сэдвийг багтаах эсвэл блок болгон тус сэдвийг илүү том талбайд багтаахад ялгаа нь оршино.

[3] Аливаа нэг материалыг хялбархан салгах зорилгоор зай үлдээн жижиг хэмжээгээр олон цоолж нүхлэхийг хэлнэ. Цооролт үүсгэх процессыг цоолбор гэнэ. Монголчууд түүнийг маркийн шүд гэж нэрлэдэг.

Зураг 14. *"ОУЦХ 100" шүдтэй марк 1965 он*



Зураг 15. *"ОУЦХ 100" шүдгүй марк 1965 он*

Манай оронд 1961 онд шуудан харилцаа холбооны ойн баярт зориулсан дурсгалын блок маркийг "Монгол шуудан 40 жил" нэртэйгээр анх хэвлүүлжээ (*Зураг 16*). Тус марк нь шуудан харилцааны үйл ажиллагааг магтан бахархаж, дөрвөн зүг найман зовхист бүх төрлийн тээврийн хэрэгслээр амжилттайгаар үйл ажиллагаагаа явуулж байгааг дүрслэн илэрхийлсэн өнгөт блок марк юм. Блок бүрийг төгсгөлгүй үргэлжлэх алхан хээгээр тойруулан чимэглэж, улсынхаа сүлдийг илүү томоор шигтгэн, үндэсний үзлийг илүү бататган харуулахаар дүрсэлсэн байна. Үүнээс үзэхэд, блок маркийн зохиомж авалтыг хийхийн тулд нэгж маркийн загвар бүрийг хэрхэн дүрслэх, нийлээд нэгдсэн агуулгын зохиомжийн найруулгыг давхар тооцоолон зохиомжлон загварчлах шаардлага үүсдэг байна. Ингэснээрээ маркийн загварыг илүү сонирхолтой өнгө үзэмж төгөлдөр бүтээх боломжтой юм.

Монгол маркийн өнгө үзэмж улам сайжирсаар ирсэн бөгөөд энэ нь тухайн үеийн хэвлэх технологитой холбоотой юм. Монгол орны ховордсон болон нэн ховордсон амьтдыг хамгаалах зорилгоор 1980 онд анх 23 каратын алтан ялтаст маркийг "Байгаль хамгаалал-1" сэдвийн хүрээнд эхний багц марк болох 10 нэгж, 1981,1982 онуудад тус сэдвийн хоёр, гурав, дөрөвдөх багц, нийт 30 нэгж алтан ялтаст маркийг өндөр технологийн аргаар хэвлэсэн байна (*Зураг 17*).

Зураг 16. *"Монгол шуудан 40 жил"анхны блок марк 1961 он*

Зураг 17. *"Байгаль хамгаалал" 1981, 1982 оны 2,3-р цувралын алтан маркаас*

Испани улсад 1982 онд зохион байгуулсан хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд зориулсан 6 нэгж маркийг Монгол, Испани улс мөн хөл бөмбөгийн онцлогийг харуулсан утга агуулга, дүрс, элемент, өнгө төрхийг шингээсэн дизайны шийдэл гарган торгон дээр хэвлэжээ (*Зураг 18*). Ийнхүү материал болон технологийн дэвшлээр монгол маркийн үнэ цэн, түүний загвар, дизайны онцлогийг илүү сонирхолтой болгосоор иржээ.

Зураг 18. *"Хөл бөмбөгийн ДАШТ Испани-82"1982 он торгон блок марк*

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаа нь Монгол шуудангийн марк нь зөвхөн үйл ажиллагааны объект төдийгүй график дизайны нарийн төвөгтэй бүтээл болохын хувьд агуулга, дүрслэлийн хөгжлийн явц түүний ач холбогдлыг онцолж байна. Ажиглалт, харьцуулалт, семиотик аргуудыг ашигласнаар бид монгол маркийн дизайны хувьсал, сэдэвчилсэн агуулга, хэв маягийн онцлогт дүн шинжилгээ хийсэн. Эдгээр аргууд нь марканд монголын соёлын онцлог, түүхийн өгүүлэмж, уран сайхны

илэрхийллийг хэрхэн багтаасан болохыг судлах боломжийг бидэнд олгосон юм.

Судалгаанаас үзэхэд, монгол маркийн график дизайн нь уламжлалт хэв маягт гүн гүнзгий шингэсэн боловч цаг хугацааны явцад орчин үеийн дизайны зарчимд зохицож ирсэн байна. Уг маркууд нь үндэсний өв соёл, түүхэн үйл явдал, байгалийн дурсгалт газрууд гэх мэт төрөл бүрийн сэдвүүдийг тусгаж, хэлбэр, өнгө, бэлгэдлийн нарийн тэнцвэртэй байдлаар толилуулжээ. Энэхүү сэдэвчилсэн олон талт байдал, дүрслэлийг боловсруулсан нь шуудангийн маркийг дэлхийн хэмжээнд соёлын элч болохыг илэрхийлж байна. Түүнчлэн, марк бүтээх үйл явцын дүн шинжилгээг диаграмм ашиглан дүрслэн үзүүлснээр бид үйлдвэрлэлийн амьдралын мөчлөгийн гол үе шатуудыг тодорхойлсон. Үйлдвэрлэлийн үйл явцын талаарх энэхүү бүтэцлэгдсэн ойлголт нь соёл, түүх, гоо зүйн асуудлууд хэрхэн нэгтгэгдэж, эцсийн дизайныг бий болгодог болохыг харуулж байна.

Энэхүү судалгаагаар монгол марк нь үндэсний урлаг, соёл, харилцаа холбооны гүүр болж хэрхэн үйлчилж байгааг онцолсон юм. Цаашдын судалгаагаар бусад орны марктай харьцуулсан судалгаа хийх, эсвэл уламжлалт марк үйлдвэрлэх үйл явцад технологийн нөлөөллийг судлах боломжтой.

Дүгнэлт

Уг судалгааны ажлын хүрээнд дараах дүгнэлтүүдийг хийж байна.

- Монголчууд нь нийгмийнхээ түүхэн хөгжлийн явцад дэлхийн бусад улсын нэгэн адил өөрийн орны үндэсний өв соёлыг дүрсэлсэн шуудангийн маркийг дэлхийн маркийн чиг баримжаанд тулгуурлан бүтээж хөгжүүлсээр иржээ.
- Монгол шуудангийн маркийн хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь агуулга төдий бус марк хэмээх энэхүү урлаг соёлын бүтээл, түүний дизайны шийдэл бөгөөд дизайнд уламжлал шинэчлэлийг хослуулах замаар өөрчлөгдөн хувирсаар өдгөө марк хэрэглэгч сонирхогчдын оюуны эрэлт хэрэгцээг хангаж байна.
- Монгол маркийн дүрслэлд монголчуудын эртний соёл болох хээлэх, чимэглэх өвөрмөц соёл өнөөг хүртэл өвлөгдөн ирсэн нь маркийн сан хөмрөгт өөрийн онцлогийг харуулсан өнгө төрхийг нэмсээр байна.
- Монгол маркийн дүрслэл дизайны хувьд элементүүдийг хураангуйллын арга, бэлгэдлийн арга, нэмэлт чимэглэлийн аргаар хувирган зохиомжлон иржээ.
- Монгол марканд сэдэв агуулгыг дүрслэхдээ ургуулан баяжуулах сэтгэлгээ давамгайлж, гол дүрслэл, өнгө аяс, хэлбэр, бичвэр зэргийг маш жижиг орон зайнд найруулан зохиомжилж үүгээрээ монгол маркийн онцлог төрхийг илэрхийлсэн байна.

Ашигласан материалын жагсаалт

Cheshire, Gerard. 2017. *A History of Victorian Postage.* Amberley Publishing.

Hill, Rowland Hill. George Birkbeck. 1880. *The Life of Sir Rowland Hill, and the History of Penny Postage.* London: Thomas de la rue and co., bunhill row.

Society, American Philatelic. 2024. *American Philatelic Society.* Accessed 2024. https://stamps.org/collect/stamp-collecting/stamp-vocabulary.

Union, Universal Postal. 2012. *Universal Postal Union.* Accessed 2012. https://www.upu.int/en/Universal-Postal-Union.

Сабур К.Н., Вильчинской-Бутенко М.Э. 2019. “Системный подход к созданию дизайна почтовой марки.” *Труды института бизнескоммуникаций:* 51-58.

Отгонбаяр, Тод. 2024. *Монгол маркийн далд түүхээс.* Улаанбаатар: Инжинаш паблишинг.

Төмөрхүү, Н. 2011. *Монгол шуудангийн түүхэн товчоон.* Улаанбаатар: Соёмбо принтинг.

Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2021. *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* Accessed 2021. https://legalinfo.mn/mn/detail/92.

Чимэд-Очир, Д. 2020. *Монгол марк сонирхогчдын гарын авлага.* Улаанбаатар: Очирпресс ХХК.